



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 26 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн өмчөөс шилжүүлсэн, нийт 1,016,018,437.00 (нэг тэрбум арван зургаан сая арван найман мянга дөрвөн зуун гучин долоо) төгрөгийн балансын үнэ, 84,974,308.00(наян дөрвөн сая есөн зуун далан дөрвөн мянга гурван зуун найм) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Э.Энхтөр, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Үл хөдлөх хөрөнгийн доорх газар эзэмших эрхийг үнэлж, данс бүртгэлд тусгах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001872
19-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын 22 өдрийн
385 дугаар тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР (ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ)-
ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1-р баг, Номгон Чандмань- 4, 4026	2020	м.кв	608.6	899,046,103.00	67,428,458.00	831,617,645.00
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн шугам сүлжээ	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1-р баг, Номгон Чандмань- 4, 4026	2020	метр		116,972,334.00	17,545,850.00	99,426,484.00
Нийт дүн						1,016,018,437.00	84,974,308.00	931,044,129.00
						(гурван зуун арван дөрвөн сая тавин зургаан мянга найман зуу)	(наян дөрвөн сая есөн зуун далан дөрвөн мянга гурван зуун найм)	(есөн зуун гучин нэгэн сая дөчин дөрвөн мянга нэг зуун хорин ес)